

**ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН ТАНИЛЦУУЛГА**

2014 оны 10 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Б.Гарамгайбаатар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо уг тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд, дараах танилцуулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн төслийн 1 дэх хэсгийг хасах зарчмын болон Тогтоолын төслийн тэмдэглэх хэсгийг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 дахь заалт, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн холбогдох заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.” гэж өөрчлөх найруулгын шинжтэй өөрчлөлтийг төсөлд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3-т зааснаар нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тогтоолын төслийн 1 дэх заалтын “Сайншанд-Замын-Үүд” гэснийг хасах санал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын дэмжлэг авлаа.

Түүнчлэн найруулгын шинжтэй тогтоолын төслийн 1 дэх заалтаас “Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээр байгуулсан нөхцөлд” гэснийг хасах санал хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авлаа.


Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ГАРАМГАЙБААТАР

**“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Сайншанд-Замын-Үүд” гэснийг хасах.

2.Найруулгын шинжтэй саналын томьёолол:

1/Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээр байгуулсан нөхцөлд” гэснийг хасах.

Эдийн засгийн байнгын хороо

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны ... дугаар
сарын ...– ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай

~~"Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 4.1.2, "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:~~

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 4.1.2 дахь заалт, 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн холбогдох заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

~~1. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулж, Монгол Хятадын хилийн төмөр замын боомтын бөлөн Монгол Улсад ашиглуулах Бүгд Найрамдах Хятад Ард Улсын далайн боомтын тоог тус тус нэмэгдүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын тээврийн нөхцөлийг урт хугацаанд төхирөх, тухайлбал, төмөр замын чиглэл, тариф, тээвэрлэх ачааны доод хэмжээ, татвар, хөлбөгдөх бусад асуудлыг хэлэлцээрт тусган шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.~~

2.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улстай Засгийн газар хоорондын дээрх хэлэлцээр байгуулсан нөхцөлд Тавантолгой–Гашуунсухайт, Сайншанд–Замын-Үүд, Хөөт–Бичигт чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1435 мм-ийн царигтай, Арц суурь–Эрдэнэт, Тавантолгой–Сайншанд–Баруун-Урт–Хөөт–Чойбалсан, Хөөт–Нөмрөг чиглэлийн төмөр замын шинэ шугамыг 1520 мм-ийн царигтай барих ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

3.2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

Гарын үсэг